

ДОРНОД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баян-Уул сумын Улзын хөгжил ОНӨААТҮГ-ыг 2021 оны санхүүгийн тайланд хийсэн  
аудитын тайлан

**Аудитын код:** ДОА-2022/04/НА/СТА-ОНА

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Улаанбаатар хот

2022 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

Тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn

Аудитын менежер: И.Сэмжидмаа

Утас: 7058-4207, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Нармандах

Утас: 7058-4207, Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Агуулга**

|                                                                           |   |
|---------------------------------------------------------------------------|---|
| 1. Аудитын санал дүгнэлт .....                                            | 3 |
| 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан .....                                   | 4 |
| 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....                           | 4 |
| 2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан.....                          | 4 |
| 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....                           | 5 |
| 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....                           | 5 |
| 2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл .....      | 5 |
| 3. Санхүүгийн тайлангийн тодруулга .....                                  | 6 |
| 3.1 Байгууллагын үйл ажилагаа .....                                       | 6 |
| 3.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин.....             | 6 |
| 3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого .....                                | 6 |
| 4. Аудитын тайлан .....                                                   | 6 |
| 4.1 Ерөнхий зүйл .....                                                    | 7 |
| 4.2 Дотоод хяналт .....                                                   | 8 |
| 4.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....                           | 8 |
| 4.4 Материаллаг байдал .....                                              | 8 |
| 5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ..... | 8 |
| 5.1 Шилэн дансны мэдээлэл.....                                            | 8 |
| 6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....                | 9 |
| 7. Дараагийн аудитаар анхаарах асуудал.....                               | 9 |
| 8. Аудитын илрүүлэлт.....                                                 | 9 |
| 8.1 Залруулсан алдаа.....                                                 | 9 |
| 9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....                         | 0 |

**Товчилсон үгийн жагсаалт**

|          |                                                        |
|----------|--------------------------------------------------------|
| АДБОУС   | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт          |
| ДОА      | Дорнод аймаг                                           |
| ИТХ      | Иргэдийн төлөөлөгчдийн хурал                           |
| НА       | Нотлох аудит                                           |
| ОНА      | Орон нутгийн өмчит аж ахуй нэгж                        |
| ОНӨААТҮГ | Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар |
| ХХОАТ    | Хувь хүний орлогын албан татвар                        |

## 1.Аудитын санал дүгнэлт



ДОРНОД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000, Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг  
ЗДП-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2022.03.14 № 343

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Г БАЯН-УУЛ СУМЫН УЛЗЫН ХӨГЖИЛ Г  
ОНӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ Т.ТӨМӨРЧУЛУУН  
ТАНАА

Г ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН Г

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Баян-Уул сумын Улзын хөгжил ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Баян-Уул сумын Улзын хөгжил ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгадагч байгууллагаас хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.БОЛОРТУУЛ



011020130

**2. Аудит хийсэн санхүүгийн тайлан****2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

| Мөрийн дугаар | Үзүүлэлт                              | /төгрөгөөр/            |                        |
|---------------|---------------------------------------|------------------------|------------------------|
|               |                                       | 2020 оны 12-р сарын 31 | 2021 оны 12-р сарын 31 |
| 1             | Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө     | 3,753,180.18           | 2,404,067.89           |
|               | Авлага                                |                        | 80,414.22              |
|               | <b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>        | <b>3,753,180.18</b>    | <b>2,484,482.11</b>    |
| 39201         | Барилга байгууламж орон сууц          | 273,879,279.00         | 273,879,279.00         |
| 39202         | Хуримтлагдсан элэгдэл                 | (47,692,048.50)        | (60,516,729.76)        |
| 39203         | Авто тээврийн хэрэгсэл                | 42,000,000.00          | 122,000,000.00         |
| 39204         | Хуримтлагдсан элэгдэл                 | (17,221,428.64)        | (20,371,428.64)        |
| 39214         | Бусад үндсэн хөрөнгө                  | 271,733,053.00         | 281,733,053.00         |
| 39215         | Хуримтлагдсан элэгдэл                 | (109,920,688.06)       | (129,778,392.53)       |
|               | <b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>    | <b>412,778,166.80</b>  | <b>466,945,781.07</b>  |
|               | <b>Нийт хөрөнгийн дүн</b>             | <b>416,531,346.98</b>  | <b>469,430,263.18</b>  |
|               | <b>Өр төлбөр ба эзэмшигчдийн өмч</b>  | <b>360,302,331.50</b>  | <b>413,201,247.70</b>  |
|               | <b>Өр төлбөр</b>                      |                        | -                      |
|               | Татварын өглөг                        |                        | -                      |
| 51200         | <b>Хуримтлагдсан үр дүн</b>           | <b>360,302,331.50</b>  | <b>413,201,247.70</b>  |
|               | Өмнөх үеийн үр дүн                    | 360,302,331.50         | 360,302,331.50         |
|               | Тайлант үеийн үр дүн                  | -                      | 52,898,916.20          |
|               | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү      | 56,229,015.48          | 56,229,015.48          |
|               | <b>Эздийн өмчийн дүн</b>              | <b>416,531,346.98</b>  | <b>469,430,263.18</b>  |
|               | <b>Өр төлбөр ба эздийн өмчийн дүн</b> | <b>416,531,346.98</b>  | <b>469,430,263.18</b>  |

**2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан**

| Мөрийн дугаар | Үзүүлэлт                                         | /төгрөгөөр/            |                        |
|---------------|--------------------------------------------------|------------------------|------------------------|
|               |                                                  | 2020 оны 12-р сарын 31 | 2021 оны 12-р сарын 31 |
| 1             | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН</b>               | <b>104,264,917.18</b>  | <b>127,987,138.00</b>  |
| 120004        | <b>Төсөвт байгууллагын өөрийн орлого</b>         | <b>23,866,918.18</b>   | <b>37,987,138.00</b>   |
| 1200041       | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих        | 23,866,918.18          | 37,987,138.00          |
| 1200017       | Үнэ төлбөргүй хүлээж авсан орлого-Үндсэн хөрөнгө | 80,397,999.00          | 90,000,000.00          |
| 2109          | <b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>           | <b>55,837,907.93</b>   | <b>75,088,221.80</b>   |
| 210901        | Бараа үйлчилгээний бусад зардал                  | 22,116,015.01          | 39,255,836.07          |
| 210903        | Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдол                | 33,721,892.92          | 35,832,385.73          |
| 3             | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН</b>                    | <b>48,427,009.25</b>   | <b>52,898,916.20</b>   |
|               | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН</b>               | <b>48,427,009.25</b>   | <b>52,898,916.20</b>   |

**2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан**

/төгрөгөөр/

| Үзүүлэлт                                                  | Өмч | Нэмж<br>төлөгдсөн<br>капитал | Хөрөнгийн<br>дахин<br>үнэлгээний<br>нэмэгдэл | Эздийн<br>өмчийн бусад<br>хэсэг | Хуримтлагдсан<br>ашиг | Нийт дүн       |
|-----------------------------------------------------------|-----|------------------------------|----------------------------------------------|---------------------------------|-----------------------|----------------|
| 2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл                       |     |                              | 56,229,015.48                                |                                 | 360,302,331.50        | 416,531,346.98 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын нөлөө алдааны залруулга |     |                              |                                              |                                 |                       | -              |
| <b>Залруулсан үлдэгдэл</b>                                |     |                              |                                              |                                 |                       | -              |
| Өмчид гарсан өөрчлөлт                                     |     |                              |                                              |                                 |                       | -              |
| Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн                 |     |                              |                                              |                                 |                       | -              |
| Тайлант оны цэвэр ашиг/алдагдал/                          |     |                              |                                              |                                 | 52,898,916.20         | 52,898,916.20  |
| <b>2021 оны 12 сарын 31-ний үлдэгдэл</b>                  | -   | -                            | 56,229,015.48                                | -                               | 413,201,247.70        | 469,430,263.18 |

**2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

/төгрөгөөр/

| Мөрийн дугаар | Үзүүлэлт                                                  | 2020 оны<br>12-р сарын 31 | 2021 оны<br>12-р сарын 31 |
|---------------|-----------------------------------------------------------|---------------------------|---------------------------|
| 1             | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН</b>                        | <b>23,866,918.18</b>      | <b>37,987,138.00</b>      |
| 120004        | <b>Төсөвт байгууллагын өөрийн орлого</b>                  | <b>23,866,918.18</b>      | <b>37,987,138.00</b>      |
| 1200041       | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих                 | 23,866,918.18             | 37,987,138.00             |
| 1.2           | <b>Мөнгөн зарлагын дүн</b>                                | <b>22,116,015.01</b>      | <b>39,336,250.29</b>      |
| 2101          | Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал                      | 10,182,708.00             | 3,281,401.00              |
| 2102          | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл            | 2,674,280.00              | 2,545,532.29              |
| 2103          | Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал                  | -                         | 354,917.00                |
| 2104          | Хангамж бараа материалын зардал                           | 6,440,050.00              | 7,970,400.00              |
| 2108          | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж    | 750,700.00                | 497,100.00                |
| 210901        | Бараа ажил үйлчилгээний бусад зардал                      | 2,068,277.01              | 24,686,900.00             |
| 1.3           | <b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b> | <b>1,750,903.17</b>       | <b>(1,349,112.29)</b>     |
| 4             | □□□ □□□□ □□□□□□ □□□□□□                                    | <b>1,750,903.17</b>       | <b>(1,349,112.29)</b>     |
| 5             | н □□□□, □□□□□□ □□□□□□ □□□□□□<br>□□□□ □□□□□□               | <b>2,002,277.01</b>       | <b>3,753,180.18</b>       |
| 6             | н □□□□, □□□□□□ □□□□□□ □□□□□□<br>□□□□□ □□□□□□              | <b>3,753,180.18</b>       | <b>2,404,067.89</b>       |

**2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл**

| № | Үзүүлэлт                | Хэмжих нэгж | 2020 оны гүйцэтгэл | 2021 оны      |               |       |      |
|---|-------------------------|-------------|--------------------|---------------|---------------|-------|------|
|   |                         |             |                    | Төлөвлөгөө    | Гүйцэтгэл     | Зөрүү | Хувь |
| 1 | Үйл ажиллагааны орлого  |             | 23,866,918.18      | 37,987,138.00 | 37,987,100.00 | -     | 100% |
| 2 | Үйл ажиллагааны зарлага |             | 22,116,015.01      | 43,089,397.18 | 43,089,397.18 | -     | 100% |

### 3. Санхүүгийн тайлангийн тодруулга

#### 3.1 Байгууллагын үйл ажиллагаа

Баян-Уул сумын Улзын хөгжил ОНӨААТҮГ-ын зорилго нь нийтийн эзэмшлийн хөрөнгийг арчлах, иргэдийн амьдрах таатай орчинг бүрдүүлэхэд оршино. Компанийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг иргэдэд үйлчлэх гэж тодорхойлжээ.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд ОНӨААТҮГ статустай байна. Өмчийн 100 хувийг орон нутаг эзэмшиж байна.

#### 3.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Баян-Уул сумын Улзын хөгжил ОНӨААТҮГ нь ИТХ-ийн 2014 оны 52 дугаар тогтоолыг үндэслэн байгуулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2.4 дэх “орон нутгийн өмчийн хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргаж, гүйцэтгэлд нь хяналт тавих” гэсэн заалттай нийцэж байна. Баян-Уул сумын Улзын хөгжил ОНӨААТҮГ нь төлөөлөн удирдах зөвлөлгүй байна.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 1.3-д “Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх,” гэж заасныг хэрэгжүүлэн ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

#### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Баян-Уул сумын Улзын хөгжил ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

| /төгрөгөөр/                                       |                       |                       |                      |
|---------------------------------------------------|-----------------------|-----------------------|----------------------|
| Үзүүлэлт                                          | Эхний үлдэгдэл        | Эцсийн үлдэгдэл       | Өөрчлөлт             |
| Б                                                 | 1                     | 2                     | 3=2-1                |
| Мөнгөн хөрөнгө                                    | 3,753,180.18          | 2,404,067.89          | (1,349,112.29)       |
| БХХО                                              |                       |                       |                      |
| Авлага                                            |                       | 80,414.22             | (80,414.22)          |
| Урьдчилгаа                                        |                       |                       |                      |
| Бараа материал                                    |                       |                       |                      |
| Үндсэн хөрөнгө                                    | 412,778,166.80        | 466,945,781.07        | 54,167,614.27        |
| Биет бус хөрөнгө                                  |                       |                       |                      |
| <b>Нийт хөрөнгийн дүн</b>                         | <b>416,531,346.98</b> | <b>469,430,263.18</b> | <b>52,738,087.76</b> |
| Өр төлбөрийн дүн                                  |                       |                       |                      |
| Богино хугацаат өглөг                             |                       |                       |                      |
| Урт хугацаат өглөг                                |                       |                       |                      |
| Эздийн өмч                                        |                       |                       |                      |
| <b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b> | <b>416,531,346.98</b> | <b>469,430,263.18</b> | <b>52,738,087.76</b> |

Банкин дахь мөнгөний үлдэгдэлд харилцах дансанд байгаа 2.4 сая төгрөг байна.

Авлага дансны үлдэгдэл 0.1 сая төгрөг нь ХХОАТ байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 677.6 сая төгрөг болж 90.0 сая төгрөгөөр өссөн нь дараах шалтгаантай байна. Үүнд: Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 80.0 сая төгрөгийн тээврийн хэрэгсэл, 10.0 сая төгрөгийн бусад хөрөнгийг шилжүүлэн авснаар нэмэгдсэн байна.

Санхүүгийн тайланд зардал өртгийн талаарх мэдээллийг бэлтгэх зорилгын дагуу үйл ажиллагааны бус зардал гэж ангилсан байна. Зардал өмнөх онтой харьцуулахад 19.4 сая төгрөгөөр нэмэгдсэн нь урсгал засвар болон үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлаас шалтгаалжээ.

### **3.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Баян-Уул сумын Улзын хөгжил ОНӨААТҮГ-ын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Баян-Уул сумын Улзын хөгжил ОНӨААТҮГ нь 2021 онд эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батлуулаагүй байна.

Сумын Засаг дарга Баян-Уул сумын Улзын хөгжил ОНӨААТҮГ-ын 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 38.0 сая төгрөгөөр, нийт зардлыг 38.0 сая төгрөгөөр тогтоосон байна.

Гүйцэтгэлээр орлого үр дүнгийн тайлангаар 128.0 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 75.2 сая төгрөгийн зардал гарган, 52.8 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 128.0 сая төгрөг байгаа бөгөөд үүнээс үйл ажиллагааны орлого 38.0 сая төгрөг, үнэ төлбөргүй шилжүүлэн авсан хөрөнгийн орлого 90,0 сая төгрөг байна.

Нийт зардлын 75.2 сая төгрөг байна. Энэ нь урсгал засвар болон үндсэн хөрөнгийн элэгдэл гол нөлөө үзүүлсэн байна.

Тайлант онд цэвэр ашиг 52.8 сая төгрөг байгаа нь орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн үнэ төлбөргүй үндсэн хөрөнгийн шилжүүлэн авснаас нөлөөлж байна.

## **4. Аудитын тайлан**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баян-Уул сумын Улзын хөгжил ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгадагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгадагч байгууллагад өглөгтэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Нармандах гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер И.Сэмжидмаа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Болортуул нар тус тус хэрэгжүүлсэн.

Баян-Уул сумын Улзын хөгжил ОНӨААТҮГ нь 2021 оны санхүүгийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 01 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

#### **4.2 Дотоод хяналт**

Баян-Уул сумын Улзын хөгжил ОНӨААТҮГ-ын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тус ОНӨААТҮГ-ын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### **4.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Баян-Уул сумын Улзын хөгжил ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

#### **4.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогоор сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны орлогын 38.0 сая төгрөгөөс 1 хувиар буюу 0.4 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **5.1 Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Баян-Уул сумын Улзын хөгжил ОНӨААТҮГ нь тайлант онд 146 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 8 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуульд заасан хугацаанд мэдээллийг байршуулж байх зөвлөмж өгөв.

## **5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэлээ.

## **6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Завсрын аудитаар алдаа зөрчил илрээгүй байна.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар түүвэрт хамрагдсан тул зөвлөмж өгөгдөөгүй байна.

## **7. Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар анхаарч үзэх асуудал байхгүй.

## **8. Аудитын илрүүлэлт**

---

Аудитаар 80.4 мянган төгрөгийн алдаа илэрснийг залруулж авлагаар тусгуулсан.

### **8.1 Залруулсан алдаа**

Санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлтэй холбоотой ХХОАТ-ын илүү төлөлтийг авлагаар тусгаагүй байсан 80.4 мянган төгрөгийн 1 алдааг залрууллаа.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

| /мянган төгрөгөөр/                                        |                          |                        |                                                                                                                              |                                                                       |                          |      |           |      |     |     |                 |     |                   |     |         |     |
|-----------------------------------------------------------|--------------------------|------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------|--------------------------|------|-----------|------|-----|-----|-----------------|-----|-------------------|-----|---------|-----|
| д/д                                                       | Байгууллагын нэр         | Аудитын код            | Алдаа зөрчлийн утга                                                                                                          | Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга                  | Нийт алдаа, зөрчлийн дүн |      | Үүнээс    |      |     |     |                 |     |                   |     |         |     |
|                                                           |                          |                        |                                                                                                                              |                                                                       |                          |      | Залруулга |      | Акт |     | Албан шаардлага |     | Хариуцлага тооцох |     | Зөвлөмж |     |
|                                                           |                          |                        |                                                                                                                              |                                                                       | Тоо                      | Дүн  | Тоо       | Дүн  | Тоо | Дүн | Тоо             | Дүн | Тоо               | Дүн | Тоо     | Дүн |
| Санхүүгийн тайлангийн асуудлаар                           |                          |                        |                                                                                                                              |                                                                       |                          |      |           |      |     |     |                 |     |                   |     |         |     |
| 1                                                         | Улзын хөгжил<br>ОНӨААТҮГ | ДОА-2022/04/НА/СТА-ОНА | ХХОАТ-ын илүү төлөлтийг татварын хэлтэс авлагаар тусгаагүй                                                                   |                                                                       | 1                        | 80.4 | 1         | 80.4 |     |     |                 |     |                   |     |         |     |
| ДҮН                                                       |                          |                        |                                                                                                                              |                                                                       | 1                        | 80.4 | 1         | 80.4 |     |     |                 |     |                   |     |         |     |
| Санхүүгийн тайлангийн асуудлаар шалгасан нийцлийн асуудал |                          |                        |                                                                                                                              |                                                                       |                          |      |           |      |     |     |                 |     |                   |     |         |     |
| 1                                                         | Улзын хөгжил<br>ОНӨААТҮГ | ДОА-2022/04/НА/СТА-ОНА | тайлант онд 146 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 8 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан. | Шилэн дансны тухай хуульд заасан хугацаанд мэдээллийг байршуулж байх. | 1                        | -    |           |      |     |     |                 |     |                   |     | 1       | -   |
| ДҮН                                                       |                          |                        |                                                                                                                              |                                                                       | 1                        | -    |           |      |     |     |                 |     |                   |     | 1       | -   |
| НИЙТ ДҮН                                                  |                          |                        |                                                                                                                              |                                                                       | 2                        | 80.4 | 1         | 80.4 |     |     |                 |     |                   |     | 1       | -   |